

**ВИЗГҮЙ ЗОРЧИХ ЖУРМЫН ТУХАЙ БҮГД НАЙРАМДАХ
МОНГОЛ АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ
СОЦИАЛИСТ РУМЫН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН КОНВЕНЦИ**

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Социалист Румын Улсын Засгийн газар, хоёр улсын хоорондын найрамдалт харилцааг хөгжүүлэн бэхжүүлэх хүсэл эрмэлзлэлийг удирдлага болгон албан ба хувийн хэргээр иргэдийнхээ зорчихыг харилцан хөнгөвчлөх зорилгоор энэхүү Конвенцийг байгуулав.

Үүний тулд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Монгол Ард Улсаас Бүгд Найрамдах Социалист Румын Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Жамбын Нямаа, Бүгд Найрамдах Социалист Румын Улсын Засгийн газар Гадаад Явдлын Яамны консулын газрын дарга Георге Бэдеску нарыг томилж, зохих хэлбэр, журмын дагуу үйлдсэн бүрэн эрхийнхээ үнэмлэхийг солилцоод дор дурьдсан зүйлийг хэлэлцэн тохиров.

Нэгдүгээр зүйл

Энэхүү Конвенцийн хавсралтанд дурьдсан, хүчин төгөлдөр зар бичгүүдийн аль нэгийг эзэмшигч Хэлэлцэн Тохирогч нэгэн Этгээдийн иргэд Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн визгүйгээр Эл этгээдийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар байх буюу дамжин өнгөрч болно.

Хоёрдугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч нэгэн Этгээдийн иргэд хүчин төгөлдөр зар бичиг, нөгөө Этгээдийн эрх бүхий байгууллагын баталгаатай урилгын үндсэн дээр Эл этгээдийн нутаг дэвсгэрт төрөл садан, нөхдийндээ айлчилж болно.

2. Онцгой тохиолдолд /хүндээр өвчлөх, нас барах/ урилгыг нутаг дэвсгэрт нь очих Хэлэлцэн Тохирогч Этгээдийн эрх бүхий байгууллагын баталсан цахилгаанаар орлуулж болно.

3. Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд урилгаа өөрийн үндэсний болон орос хэл дээр үйлдэнэ. Урилга нь олгосон өдрөөс эхлэн нэг жилийн туршид хүчинтэй байна.

Гуравдугаар зүйл

Хоёр Этгээдийн жуулчны байгууллагын хооронд байгуулсан хэлэлцээрийн үндсэн дээр, Хэлэлцэн Тохирогч нэгэн Этгээдийн иргэд визгүйгээр ганц нэгээр буюу хэсэг бүлгээрээ Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэрт жуулчилж болно.

Дөрөвдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа Хэлэлцэн Тохирогч нэгэн Этгээдийн иргэд оршин суугаа улсаас гарч, орохдоо Эл этгээдийн хууль, дүрмийг баримтлан дагана.

Тавдугаар зүйл

1. Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд энэхүү Конвенцийн хавсралтанд дурьдсан зар бичиг болон урилгын загварыг дипломат шугамаар солилцож байна.

2. Хэрэв зорчих зар бичгүүд, урилгыг өөрчлөх буюу шинэ зар бичиг хэрэглэвэл Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд дипломат шугамаар нэг нь нөгөөдөө мэдээлэхийн хамт тэдгээр зар бичгийн загварыг илгээнэ.

Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдэд шинэ зар бичгийн загварыг өгч, мэдэгдсэн өдрөөс хойш 30 хоногийн дараа уг зар бичгийг хэрэглэж болно.

Зургаадугаар зүйл

Хэлэлцэн Тохирогч нэгэн Этгээдийн иргэд, Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэрт олон улсын зорчигчдийг нэвтрүүлдэг хилийн аль ч боомтоор орж, гарч болно.

Долдугаар зүйл

1. Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэрт албан хэргээр яваа Хэлэлцэн Тохирогч нэгэн Этгээдийн иргэд албан үүргээ гүйцэтгэх хугацааны туршид тэр улсын нутаг дэвсгэрт байж болно.

Хэрэв тэдгээрийн гэр бүлийн гишүүд нь мөн улсын харьяат бол тэдэнд энэ заалт нэгэн адил хамаарна.

2. Энэхүү Конвенцийн хоёрдугаар зүйлийн дагуу Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэрт хувийн хэргээр яваа Хэлэлцэн Тохирогч нэгэн Этгээдийн иргэд нөгөө улсын хилийг давсан өдрөөс хойш энэ нутаг дэвсгэрт 60 хоног байх эрхтэй. Хүндээр өвчлөх, төрөх, нас барах, гэрлэх болон адилтгах бусад тохиолдлуудад нутаг дэвсгэрт нь очсон улсын эрх бүхий байгууллага байх хугацааг 30 хоног хүртэл сунгаж болно. Хугацааг сунгахдаа хураамжаас чөлөөлнө.

3. Хэлэлцэн Тохирогч нэгэн Этгээдийн иргэд Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн хууль дүрмийн дагуу Эл этгээдийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрнө.

Наймдугаар зүйл

1. Хэлэлцэн Тохирогч нэгэн Этгээдийн иргэд Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэрт зар бичгээ хаяж үрэгдүүлсэн, эсвэл зар бичиг нь гэмтээгдсэн буюу устгагдсан бол орон нутгийн эрх бүхий байгууллагад энэ тухайгаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

2. Энэ зүйлийн нэгдүгээрт дурьдсан болон түүнчлэн Хэлэлцэн Тохирогч нэгэн Этгээдийн нутаг дэвсгэрт яваа Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн группийн паспортанд бичигдсэн иргэдийн аль нэг нь хүндэтгэх шалтгаанаар айлчлалтаа зогсоовол, уг иргэнийг харъяалах улсын дипломат төлөөлөгчийн буюу консулын газар эх орондоо буцахад нь зориулан түүний зураг бүхий шинэ зар бичгийг олгоно.

Есдүгээр зүйл

1. Хэлэлцэн Тохирогч нэгэн Этгээдийн иргэд Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар байхдаа суугаа улсын хууль дүрмийг хүндэтгэн биелүүлэх үүрэгтэй.

2. Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн тааламжгүй гэж үзсэн иргэдийг Хэлэлцэн Тохирогч нэгэн Этгээд өөрийн нутаг дэвсгэрт оруулахаас татгалзах, тэдгээрийн байх хугацааг богиносгох, айлчлалтыг зогсоох, түүнчлэн хөөн явуулах эрхийг энэхүү Конвенцийн заалт хөндөхгүй.

3. Хэлэлцэн Тохирогч нэгэн Этгээдийн эрх бүхий байгууллагууд, Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн иргэдийн айлчлалтын хугацааг богиносгох буюу зогсоох талаар авсан арга хэмжээгээ Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт нэн даруй мэдэгдэж байна.

Аравдугаар зүйл

Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд, энэхүү Конвенцийг биелүүлэхтэй холбогдон гарах асуудлаар шаардлага гарвал дипломат шугамаар зөвлөж байна.

Арваннэгдүгээр зүйл

Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд тохиролцсоны үндсэн дээр шаардлагатай үед энэхүү Конвенцийн зарим заалтанд нэмэлт буюу өөрчлөлт оруулж болно.

Арванхоёрдугаар зүйл

1. Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээдийн хууль тогтоомжийн дагуу батласныг мэдэгдсэн нот солилцсон өдрөөс хойш 30 хоногийн дараа энэхүү Конвенци хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү Конвенцийг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн визгүйгээр зорчих журмын тухай Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээдийн хооронд урьд өмнө байгуулсан хэлэлцээрүүд хүчингүй болно.

Арвангуравдугаар зүйл

Энэхүү Конвенцийг хугацаагүйгээр байгуулсан бөгөөд Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээдийн аль нэг нь цуцлах тухайгаа бичгээр мэдэгдсэн өдрөөс хойш 6 сар туршид хүчин төгөлдөр байна.

Энэхүү Конвенцийг 1974 оны 10-р сарын 14-ны өдөр Бухарест хотноо монгол, румын, орос хэл дээр гурван хувь үйлдсэн бөгөөд хувь тус бүр адил хүчинтэй байна.

Монгол, румын хэл дээрхи хувиудыг тайлбарлах үед зөрөө гарвал орос хувийг баримтлана.

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ
АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ЭРХ ОЛГОСНООР**

Гарын үсэг

**БҮГД НАЙРАМДАХ СОЦИАЛИСТ
РУМЫН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ЭРХ ОЛГОСНООР**

Гарын үсэг

**“Визгүй зорчих журмын тухай Бүгд Найрамдах
Монгол Ард Улсын Засгийн газар,
Бүгд Найрамдах Социалист Румын Улсын
Засгийн газар хоорондын Конвенц”-ийн
ХАВСРАЛТ**

1. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын иргэд хил нэвтрэхдээ дараах зар бичгийг хэрэглэнэ.

- дипломат паспорт
- албан паспорт
- энгийн паспорт /иргэний гадаад паспорт Гадаад Явдлын Яамнаас олгоно/
- Бүгд Найрамдах Монгол Ард Улсад буцах үнэмлэх
- гадаад паспортын хавсралт
- энгийн паспорт /гадаадад явах паспорт Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамнаас олгоно/
- гадаадад түр хугацаагаар явах гэрчилгээ
- 16 хүртэлх насны хүүхэд өөрт нь олгосон зар бичгээр, эсвэл эцэг, эх буюу бусдын зар бичигт бичигдсэн бол тэдгээрийн зар бичгээр зорчино.

2. Румын иргэд хил нэвтрэхдээ дараах зар бичгийг хэрэглэнэ.

а. Албан хэргээр зорчиход

- дипломат паспорт
- албан паспорт
- ганц нэгээр буюу группээр явах хүмүүст Гадаад Явдлын Яамнаас олгодог энгийн паспорт
- далайчдын албан ажлын үнэмлэх
- иргэний агаарын тээврийн нисэх бүрэлдэхүүний гишүүдийн албан ажлын үнэмлэх

б. Хувийн хэрэг, жуулчлалаар зорчиход

- дипломат паспорт
- байнгын албан үүрэг гүйцэтгэж байгаа хүмүүст олгодог албан паспорт
- ганц нэгээр буюу группээр явах хүмүүст Дотоод Яамнаас олгодог энгийн паспорт
- гадаадад байнга оршин суудаг румын иргэдэд олгодог паспорт

в. Албан ба хувийн хэрэг, жуулчлалын журмаар группээр зорчигсодод

- группийн ахлагчийн нэр дээр олгодог албан ба энгийн паспорт, энэ паспортыг олгосон байгууллагын баталгаа бүхий нэрсийн жагсаалтыг хавсаргана. Нэрсийн жагсаалтанд хүмүүсийн биеийн байцаалтийн талаар бичиж зургийг наана. Хэрэв нэрсийн жагсаалт нь хүмүүсийн зураггүй бол түүнд овог нэр болон тэдгээрийг гэрчлэх үнэмлэхийн дугаарыг бичсэн байна.

г. 14 хүртэлх насны хүүхдүүд

- Хэрэв эцэг, эхийн аль нэгийг зар бичигт бичигдсэн бол тэдгээрийн хамт зорчино.
- хэрэв ганцаараа явбал түүний зураг бүхий зар бичгээр зорчино.

д. Энэ хавсралтын 2-ын а.б.в.г-д дурьдсан зар бичгүүдийн аль нэгээр дамжин өнгөрч болно.

**Бухарест хотноо 1974 оны 10-р сарын 14-ны өдөр
байгуулсан “Визгүй зорчих журмын тухай
Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн
газар, Бүгд Найрамдах Социалист Румын Улсын
Засгийн газар хоорондын Конвенц”-ийн
НЭМЭЛТ ПРОТОКОЛ**

Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд доорх зүйлийг тохиролцсон нь:

Нэгдүгээр зүйл

Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэр дээр суугаа Хэлэлцэн Тохирогч нэгэн Этгээдийн дипломат, консул, худалдааны төлөөлөгчийн газрын гишүүдийн төрөл садан, түүнчлэн мөн улсын харьяат бөгөөд олон улсын байгууллагад ажилладаг хүмүүсийн төрөл садан тэдэндээ айлчлахаар явахад нь Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд гарах-орох визинд нь “Т” үсэг бичсэн байвал Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн визгүй, урилгагүйгээр Эл этгээдийн нутаг дэвсгэрт зорчиж болно.

Хоёрдугаар зүйл

Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэрт албан ажлаар явах Хэлэлцэн Тохирогч нэгэн Этгээдийн иргэд байр, үйлчилгээний бүх зардлыг өөрөө хариуцах нөхцөлд гэр бүлийнхээ нэг гишүүнийг урилгагүйгээр, Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн орох-гарах визийн үндсэн дээр дагуулж явж болно.

Гуравдугаар зүйл

Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар суугаа албан ба энгийн паспортыг эзэмшигч Хэлэлцэн Тохирогч нэгэн Этгээдийн иргэдийн зар бичиг нь гурав дахь оронд нэвтрэхэд хүчин төгөлдөр бус бол Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээдийн эрх бүхий байгууллага тэднийг явуулахгүй байх арга хэмжээг авна.

Дөрөвдүгээр зүйл

Визгүй зорчих журмын тухай Конвенцийн заалтанд тусгагдаагүй бусад тохиолдолд Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэрт зорчихыг хүссэн Хэлэлцэн Тохирогч нэгэн Этгээдийн иргэдэд хураамжгүйгээр виз олгоно.

Тавдугаар зүйл

Энэхүү нэмэлт протокол нь Бухарест хотноо 1974 оны 10-р сарын 14-нд байгуулсан “Визгүй зорчих журмын тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Социалист Румын Улсын Засгийн газар хоорондын Конвенц”-ийн салшгүй хэсэг мөн.

Энэхүү нэмэлт протоколыг нийтлэхгүй гэж Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд тохиролцов.

Бухарест хотноо 1974 оны 10-р сарын 14-ны өдөр монгол, румын, орос хэл дээр гурван эх хувь үйлдэв. Эх хувь тус бүр адил хүчинтэй.

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЭРХ
ОЛГОСНООР**

Гарын үсэг

**БҮГД НАЙРАМДАХ СОЦИАЛИСТ
РУМЫН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ЭРХ ОЛГОСНООР**

Гарын үсэг